



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН  
ТОГТООЛ**

2020 оны 02 сарын 18 өдөр

Дугаар 52

Улаанбаатар хот

**“Автотээврийн үндэсний төв”  
төрийн өмчит үйлдвэрийн газрын  
зохион байгуулалтын бүтэц, орон тооны дээд  
хязгаарыг шинэчлэн батлах тухай**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 5 дахь хэсэг, “Автотээврийн үндэсний төв” төрийн өмчит үйлдвэрийн газрын дүрмийн 6.6 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Автотээврийн үндэсний төв” төрийн өмчит үйлдвэрийн газрын зохион байгуулалтын бүтцийг дор дурдсанаар шинэчлэн баталсугай:

- 1.1. Тээвэр зохицуулалтын хэлтэс (Ачаа тээврийн тасаг, Мэргэшсэн жолоочийн сургалтын тасаг, зорчигч тээврийн тасагтай);
- 1.2. Авто үйлчилгээний хэлтэс;
- 1.3. Хөдөлгөөний удирдлагын хэлтэс (Хяналтын тасагтай);
- 1.4. Захиргаа, сургалт, хүний нөөцийн хэлтэс (Хууль, эрх зүйн тасаг)
- 1.5. Санхүү, эдийн засгийн хэлтэс;
- 1.6. Техникийн хяналтын хэлтэс;
- 1.7. Тээврийн хэрэгслийн бүртгэлийн хэлтэс (Архив, лавлагааны тасаг, Өмчлөгчийн бүртгэлийн тасаг, Бүртгэл хяналтын тасагтай);
- 1.8. Мэдээлэл технологийн тасаг;
- 1.9. Хяналт-шинжилгээ, дотоод аудитын алба.

2. “Автотээврийн үндэсний төв” төрийн өмчит үйлдвэрийн газрын зохион байгуулалтын бүтцийн схемийг хавсралтаар шинэчлэн баталсугай.

3. “Автотээврийн үндэсний төв” төрийн өмчит үйлдвэрийн газрын орон тооны дээд хязгаарыг 819 (найман зуун арван ес) байхаар тогтоосугай.

4. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтэс (Ц.Баяр-Эрдэнэ)-т үүрэг болгосугай.

5. Энэ тогтоол гарсантай холбогдуулан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2017 оны 14 дүгээр тогтоолын 1 дэх заалт, 1 дүгээр хавсралтыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА


ТӨРИЙН ӨМЧИЙН УДИРДЛАГА,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ХЭЛТЭСИЙН  
ДАРГА

З.МЭНДСАЙХАН

Ц.БАЯР-ЭРДЭНЭ

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2020 оны 02 дугаар сарын 8 -ны өдрийн 54 тогтоолын дүгээр хавсралт

НИЙТ ОРОН ТОО: 819



УЛААНБААТАР ХОТ ДАХЬ ТӨВ: СУДАЛГАА, ХӨГЖИЛ, ЧАНАРЫН УДИРДЛАГЫН ТӨВ-(1)  
 ТЕХНИКИЙН ХЯНАЛТЫН ҮЗЛЭГИЙН ТӨВ-(3)  
 ЗОРЧИГЧ ТЭЭВРИЙН ТӨВ (АВТОБУУДАЛ)-(2)

ОРОН НУТАГ ДАХЬ ТӨВ, САЛБАР: АЙМГИЙН АВТОТЭЭВРИЙН ТӨВ -(21)

ЗАМЫН-ҮҮД САЛБАР - (1)  
 ЦОГЦЭЦЭЙ САЛБАР -(1)